

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны долдугаар сарын 02-ны 14 цаг 05 минутад эхэлж, 14 цаг 59 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 54 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Аж үйлдвэрийн яамны зарим албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p> <ul style="list-style-type: none">- Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилогдох- Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилогдох- Жижиг, дунд үйлвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд томилогдох- Хөнгөн үйлдвэрийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилогдох	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1.Доржготовын Баттогтохыг Аж үйлдвэрийн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын, Шаравсамбуугийн Гэрэлчимэг, Сандагийн Балжинням нарыг Хөнгөн үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын даргын, Ганбатын Билгүүнийг Жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын, Ганхуягийн Мөнхбатыг Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд тус тус томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Төрийн албаны зөвлөлийн Уул уурхайн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар</p>

		<p>тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.2, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг"-ийг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын "нэг"-ийн 10-т Төрийн албаны зөвлөлийн Уул уурхайн яамны дэргэдэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар өөрчлөн баталсугай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн нарийн бичгийн дарга, 2. Төрийн захиргааны удирдлагын газрын дарга 3. Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга 4. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга 5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга 6. Түлшний бодлого зохицуулалтын газрын дарга 7. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмалын газрын дарга 8. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын тосны газрын дарга 9. Төрийн захиргааны удирдлагын газрын хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн. <p>тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	Төрийн албаны зөвлөлийн Гадаад хэргийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Гадаад хэргийн сайдын 2015 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 02/3587 тоот албан бичгээр ирүүлсэн</p>

		<p>хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Гадаад хэргийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргаар тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Дамбын Ганхуягийг 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн томилох.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын “Нэг”-ийн 5-д “Гадаад харилцааны яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга -яамны Төрийн нарийн бичгийн дарга Гомбын Цогтсайхан” гэснийг “Төрийн албаны зөвлөлийн Гадаад хэргийн яамны дэргэдэх салбар зөвлөлийн дарга -яамны Төрийн нарийн бичгийн дарга Дамбын Ганхуяг ” гэж өөрчлөх.</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Д.Ганхуягт үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.4 дэх заалтыг баримтлан, Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргын 2015 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p>

		<p>1. Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус газрын Хүний нөөц сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Лхагвын Отгонсүрэнг 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн томилох</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын “хоёр”-ын 3-т “..Хүний нөөцийн хэлтсийн ахлах байцаагч Пүрвээгийн Оюунтунгалаг” гэснийг “...Хүний нөөц, сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Лхагвын Отгонсүрэн” гэж өөрчлөх.</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Л.Отгонсүрэнд үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
5	Зарим хүмүүсийг "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах тухай	<p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачлагатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан дараах нэр бүхий 16 төрийн албан хаагчдыг Монгол Улсын “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнах</p> <p>2. Шагнагдсан хүн тус бүрийн тэмдгийг дагалдах мөнгөн шагнал (хоёр зуун мянган төгрөг)-ыг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар</p>

		<p>баталсан “Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам”-ын 4.2-т заасны дагуу шагнагдагсдад тухайн байгууллагаас олгох</p> <p>3. Шагнагдсан нийт төрийн албан хаагчдад баяр хүргэж, ажлын амжилт хүсэх тухай Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар шийдвэрлэв.</p>
--	--	--